



ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ  
**БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН УЛСЫН ХОРООНЫ**  
**ДАРГЫН ТУШААЛ**

2024 оны 01 сарын 31-өдөр

Дугаар 1/40

Улаанбаатар хот

Г Дугуйн спортын Үндэсний шигшээ  
багийн бүрэлдэхүүн батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.1 дэх заалт, 8.4 дэх хэсэг, Биеийн тамир, спортын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.7, 11 дүгээр зүйлийн 11.3.7, 11.3.9, 18 дугаар зүйлийн 18.3, 18.4, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсэг, Монгол Улсын сайд, Олимп, нийтийн биеийн тамир, спортын Үндэсний хорооны даргын 2023 оны А/22 дугаар тушаалаар батлагдсан “Үндэсний шигшээ багийг бүрдүүлэх спортын төрлийг сонгох, санхүүжүүлэх журам”-ыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Дугуйн спортын Үндэсний шигшээ багийн бүрэлдэхүүний нэрсийг хавсралтаар баталсугай.

2. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийг ханганд тус хуулийн 08 дугаар зүйлд заагдсан нээлттэй мэдээллийг байгууллагын цахим хуудсанд байршуулан мэдээллийн ил тод байдлыг ханганд ажиллахыг Монголын Дугуйн спортын холбоонд үүрэг болгосугай.

3. Батлагдсан бүрэлдэхүүн, орон тооны дагуу цалин, нийгмийн даатгалын шимтгэлийг сар бүр Дугуйн спортын холбоонд шилжүүлэхийг Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн ерөнхий нягтлан бодогч (А.Өнөрцэцэг)-д зөвшөөрсүгэй.

4. Цалин, нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлан, хувь хүний орлогын албан татварын тайланг улирал тутам хянаж, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг ханганд ажиллахыг Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтэс (Д.Цэрэнболд)-т, холбооны саналыг үндэслэн бүрэлдэхүүн хөдөлгөөнд тухай бүр өөрчлөлт оруулахыг Үндэсний шигшээ багийн бодлогын хэрэгжилтийн хэлтэс (Э.Билэгт)-т тус тус үүрэг болгосугай.

5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавин ажиллахыг Хяналт-шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын хэлтэс (Н.Батсүх)-т даалгасугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР  
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



О.БАТТУЛГА

142491124

Биеийн тамир, спортын улсын хорооны  
даргын 2024 оны 01 дугаар сарын 01-ны  
өдрийн 10 дугаар тушаалын хавсралт

ДУГУЙН СПОРТЫН ҮНДЭСНИЙ ШИГШЭЭ  
БАГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

| № | Овог       | Нэр           | Үүрэг         |
|---|------------|---------------|---------------|
| 1 | Туулхангай | Төгөлдөр      | дасгалжуулагч |
| 2 | Сайнбаяр   | Жамбалжамц    | тамирчин      |
| 3 | Батсайхан  | Тэгшбаяр      | тамирчин      |
| 4 | Эрдэнэбат  | Билгүүнжаргал | тамирчин      |
| 5 | Баасанхүү  | Мягмарсүрэн   | тамирчин      |
| 6 | Хадбаатар  | Тэмүүлэн      | тамирчин      |
| 7 | Алтангэрэл | Даваажаргал   | тамирчин      |
| 8 | Бат-Эрдэнэ | Наранхүү      | тамирчин      |
| 9 | Батсамбуу  | Батбаатар     | тамирчин      |

--оо--